



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№223 /432/

2022.12.11

Тусгай дугаар



## БАЙЛДААНЫ ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН БОЛОН БАЙЛДААНЫ ГАВЬЯАНЫ ОДОНТ ЦЭРГИЙН ДУУ БҮЖГИЙН ЭРДМИЙН ЧУУЛГА ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ 90 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНДИЙГ ӨРГӨН ДЭВШҮҮЛЬЕ

### МЭНДЧИЛТЭЭ

### ШАГНАЛЫН ХУР БУУЛАА



хүндтэй үүргийг нэр төртэй биелүүлж ирсэн түүхтэй.

Чуулгын хамт олон 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайны хүнд цаг үед цэрэг дайчидтайгаа хамт байж "Түүхэн хил", "Байлдаанч суман", "Чамайг үдье", "Эх орон", "Маргааш цэрэгт мордоно" зэрэг дуунууд "Монгол бүжиг", "Бид хөдөлмөрлөхдөө", "Сэлэмт бүжиг", "Аж ахуй" зэрэг бүжгүүд, "Орос ардын аялгуу", "Сарны туяа", "Амар мөрний давлагаа" зэрэг хөгжмийн бүтээлүүдээ толилуулан ялалтад зоригжуулж байсныг бахархан тэмдэглэж байна.

Тус чуулга нь олон шилдэг уран бүтээлчдийг бэлтгэн гаргаж, урлагийн тайзанд мөнхөрсөн цэрэг, эх орны сэдэвт арвин их бүтээлээр ард түмнээ соён гэгээрүүлж, сайн сайхан ирээдүйд итгэх итгэл, монгол хүн болж төрснөөрөө бахархах, эх оронч үэлийг түгээн дэлгэрүүлж, орчин цагийн Монголын соёл урлагийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсан мэргэжлийн байгууллага билээ.

Чуулгын уран бүтээлчдийн амжилт, байгуулсан гавьяаг төр засаг өндрөөр үнэлэн 1962 онд "Байлдааны гавьяаны одон", 1982 онд "Байлдааны гавьяаны улаан тугийн одон"-гоор тус тус шагнаж, 2002 онд "Эрдмийн чуулга" гэсэн эрхэм алдрыг хүртээсэн бөгөөд олон улсын болон өөрийн орны өндөр хүндэтгэлтэй шагналуудыг

удаа дараа хүртсэн нь уран бүтээлүүдээ мэргэжлийн өндөр түвшинд бүтээн туурвиж байгаагийн үнэлэмж илэрхийлэл юм.

Цэрэг дайчдын соёлын томоохон төв болон өргөжин хөгжсөн танай хамт олон сүүлийн жилүүдэд "Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх" үндэсний хөтөлбөр, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Бидний бахархал" төсөл зэрэг төр засгаас хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийг урлаг, уран сайхнаар дамжуулан ард иргэдэд түгээж байгаад Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зүгээс талархал илэрхийлж, цаашдын урлагийн их үйлсэд нь улам их амжилтыг хүсэн ерөөе.

Цэрэг, эх оронч уран бүтээлийг тасралтгүй туурвиж, хойч үедээ уламжлан үлдээж өвлүүлэх, үзэгч олон түмэндээ шинэ уран бүтээлийг өргөн барихын төлөө цаг ямагт хичээнгүйлэн зүтгэж, эрч хүч, оюун мэдлэг, авьяас чадвар, хөдөлмөр зүтгэлээ харамгүй зориулсан ахмад үеийнхэн болон тэдний үйл хэргийг нэр төртэй залгамжилж яваа уран бүтээлчид, ажилтан албан хаагч Та бүхэнд эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсье.

Энэ цаг мөчид түүхэн яруу алдарт Байлдааны гавьяаны Улаан тугийн болон Байлдааны гавьяаны одонт Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын хамт олон 90 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн тоглолтоо ёслол төгөлдөр зохион байгуулж байна.



Баярын хурлыг нээж ЦДБЭЧ-ын дарга, СТӨ-ний Ерөнхий менежер хурандаа Г.Золзаяа хэлсэн үгэндээ "Чуулгын 90 жилийн түүх бол Монгол Улсын театр, хөгжмийн урлагийг шинэ нөхцөлд үүсгэн хөгжүүлэхэд оруулсан жинтэй хувь нэмрийн илэрхийлэл, цэрэг, дайчид, ард иргэдийг эх оронч үзлээр хүмүүжүүлэн зоригжуулж дайны фронт, хилийн торгон шугам, хөдөлмөрийн талбарт төдийгүй гадаадын олон мянган зочид төлөөлөгчдөд монгол үндэстний соёл урлагийн ололт, амжилт, өвөрмөц гайхамшгийг таниулан сурталчилсан үйлс, театр, хөгжмийн урлагт олон зуун шилдэг боловсон хүчнийг бэлтгэн гаргаж, Зэвсэгт хүчний эгнээнээс ХХ зууны манлай уран бүтээлчид, Монголын урлагийн суу алдартнууд, нэрт зүтгэлтнүүдийг төрүүлсэн эрхэм гавьяаны тод илрэл болохыг онцлоод өнөөдрийн өрнүүн их түүхийг бичилцэж, улсаа хайрлах сэтгэлийг урлагийн сайхнаар түгээх эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө эрч хүч, оюун мэдлэг, авьяас чадвар, хөдөлмөр зүтгэлээ харамгүй зориулсан ахмад үеийнхэн болон тэдний үйл хэргийг нэр төртэй залгамжилж яваа уран бүтээлчид, ажилтан алба хаагчдад түүхт ойн баярын мэндийг өргөн дэвшүүлсэн юм.

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЕРӨНХИЙ КОМАНДЛАГЧ УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ



Үргэлжлүүлэн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын ЦДБЭЧ-ын 90 жилийн ойд зориулж баяр хүргэсэн мэндчилгээг Батлан хамгаалахын дэд сайд хүрэлцэн ирсэн зочид, нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцууллаа.

Арга хэмжээний төгсгөлд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар ЦДБЭЧ-ын дарга, СТӨ-ийн ерөнхий менежер хурандаа Г.Золзаяа МУСГЗ цол тэмдгээр шагнасан бөгөөд мөн ЦДБЭЧ-д он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, уран бүтээлийн өндөр амжилт гаргасан нийт 200 гаруй алба хаагчдыг Төрийн болон Батлан хамгаалах салбарын одон медалиар шагнаж урамшууллаа





АХМАДУУД ЯРЬЖ БАЙНА

ДУУСАШГҮЙ ИХ ЖАРГАЛ, ДУНДАРШГҮЙ ИХ ТҮҮХ ТУС ГАЗАРТ БИЙ

Концертмейстер-Төгөлдөр хуурч, МУГЖ, бэлтгэл ахлах ахлагч Б.УУШАНЗ:

-Би 1945 онд Сэлэнгэ аймгийн Зэлтэрийн САА-ын малын эмч н.Гармаа, багш Ханд нарын ууган охин нь болон мэндэлсэн. Тухайн үед ижий, аав хоёр минь үр хүүхэдгүй Буяндалайн гэр бүлд намайг өргүүлсэн юм билээ. Өргөсөн аав Буяндалай маань намайг урлагийн авьяастайг мэдээд бүх талаар дэмжиж дуулж, бүжиглэх, хөгжим тоглохыг зааж сургасан. Ийнхүү дөнгөж наймхан настай байхдаа МАХН-ын XII их хуралд зориулсан тоглолтод оролцох сонгон шалгаруулалтад тэнцэж байлаа. Энэ бол миний анхны томоохон тайз бөгөөд урлагийн алтан шаргал замд хөтлөх эхлэл байсан гэж боддог. Түүнээс хойш удалгүй Соёлын яамны шийдвэр гарч ЗХУ-ын Ленинград хотын хөгжмийн дунд сургуульд 1954-1964 он хүртэл суралцсан.

Урлагийн бурхад чуулсан ЦДБЭЧ гэх энэ газар 1966-1989 он хүртэл ажиллахдаа концертмейстер-төгөлдөр хуурч албан тушаалыг хашсан. Тухайлбал ансамблийн гоцлон дуулаачид МУГЖ Дашням, Тунгалаг, Туул, Цэрэнпил, Ардын жүжигчин Баярмагнай болон Баянмөнх ахлагчтай эмэгтэй чуулгын дасгалжуулагч, багшийн үүргийг гүйцэтгэн хамтран уран бүтээл туурвидаг байв. Жишээлбэл 1978 онд болсон Улсын Үндэсний хөгжмийн анхдугаар уралдаанд МУГЖ Мэнд-Амар, МУСТА Нансалмаа, МУСТА Чалхаасүрэн, МУСТА Батнасан, Наранцэцэг



нартай хамтран уран бүтээл хийж түүгээрээ тэмцээний тэргүүн байруудыг эзэлж байлаа. Мөн зохиолын дуу дуулаачдын анхдугаар тэмцээнд МУГЖ Дашням, МУГЖ Тунгалаг нартай хамт оролцож тэргүүн болон удаах байруудад шалгарч байлаа. Энэ мэт яривал дуусахгүй их жаргал, дундаршгүй их түүх тус газарт бий. Ингээд олон зүйлийг эс нурушин өнөөгийн ЦДБЭЧ-ын хамт олондоо, мөрдэс нэгт нөхдөдөө уран бүтээлийн өндөр амжилтыг хүсье.

ЦЭРГИЙН ДУУ БҮЖГИЙН ЭРДМИЙН ЧУУЛГА БОЛ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ЭХ ҮЙЛСИЙН УНДАРГА БОЛСОН ГАЗАР



Аж ахуйн дарга, зохион байгуулагч МУСТА С.АЛТАНЧИМЭГ:

-Алдар гавьяаны хос одонт чуулгынхаа 90 жилийг үзэх гэж буйдаа туйлын баяртай байна. Анх 1975 онд тус чуулгад бичээч болон бичиг хэргийн эрхлэгчийн албан тушаалд томилогдож ажил, амьдралын гараагаа эхлэж байв. Би 36 жил ажиллах хугацаандаа зохион байгуулагч, зохион байгуулах ангийн дарга, аж ахуйн дарга-зохион байгуулагч зэрэг албан тушаалыг хашиж

байгаад 2011 онд тэтгэвэртээ гарсан. Товчхондоо Офицеруудын ордон, ЦДБЭЧ бол соён гэгээрүүлэх эх үйлсийн ундарга болсон газар. Тухайлбал Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд хамааралтай бүхий л томоохон үйл явдлын урлагийн арга хэмжээг энэ газар зохион байгуулдаг. Үргэлжид баяр баясал, инээд хөөр, дуу хуурын эгшиг тасардаггүй газар. Одоо ч тус үйл хэргийг дүү нар, найз нөхөд болсон хамт олон минь үргэлжлүүлсээр байна.

Цэргийн уран бүтээлчид гэдэг хөдөө орон нутагт маш их цаг хугацааг өнгөрүүлж томиллолтоор бригад болон ажилладаг. Тэр бүхэнд арын албаны бид бүрэн бүрэлдэхүүнээрээ дагалдан явж суртал ухуулга болон үйлчилгээний ажлыг нугалдаг байв. Уран бүтээлчдээ тайзан дээр гаргачаад өөрсдөө гарчихсан мэт сандарна, үзэгчдийн алга ташилт сонсоод өөрсдөө тоглосон мэт баяр хөөрийг мэдэрдэг байж билээ. Манай хамт олны хувьд хөдөлмөрч, хичээл зүтгэлтэй, хариуцлагатай байдлаараа манлайлагч байсан учир уран бүтээлчдийнхээ хөдөлмөрийг үнэгүйдүүлэгүй ар талыг найдвартай дааж чаддаг байсан. Энэ ч утгаараа миний бие төр засагтаа өндрөөр үнэлүүлж МУСТА, Хөдөлмөрийн хүндэт медаль, Алтангадас зэрэг эрхэм хүндэт цол, медалиудын эзэн болж байлаа. Олон ч дарга нартай гар нийлэн ажиллаж мөн ч их түүх, дурсамжийг энэ газарт үлдээсэн дээ.

Ингээд өдгөө 90 жилийн түүхт ойн баяраа тэмдэглэж буй хамт мөр зэрэгцэн алба хааж байж байсан үе, үеийн ажилтан, алба хаагчид, удирдлага болон ахмадууддаа ойн баярын мэндийг хүргэе. Та бүхний минь ажил үйлс нь бүтэмжтэй, эрүүл энх, саруул сайхан байхыг хүсэн ерөөе.

МИНИЙ АМЬДРАЛЫГ ТУС ЧУУЛГАГҮЙГЭЭР ТӨСӨӨЛӨХ БОЛОМЖГҮЙ

Ахмад уран бүтээлч, Ахмадын хорооны тэргүүлэгч, МУГЖ, бэлтгэл ахлагч Г.БАТНАСАН:

-Анх дунд сургуулиа дүүргээд 1966 онд Завхан аймгийн Соёлын ордонд дагалдан хөгжимчнөөр ажил, амьдралын гараагаа эхлүүлсэн. Ийнхүү явахдаа 1971 онд эр цэргийн албанд татагдаж тухайн үед Цагаан карантин хэмээн нэрлэдэг байсан газар албаа хаасан юм. Тэнд байхад маань Урлагийн гавьяат зүтгэлтэн Ш.Гунаажав багш маань ирж авьяас чадварыг минь шалгаж үзээд Ардын Армийн дуу бүжгийн ансамбльдээ элсүүлж байлаа.

Миний амьдралыг чуулгагүйгээр төсөөлөх аргагүй. Учир нь 40 гаруй жил ажилласан байна. 1932 онд тус чуулга үүсэн байгуулагдсанаас хойш хөгжмийн авьяаслаг уран бүтээлчид энэ газраас олон арваараа төрөн гарсан байдаг. Тухайлбал Алдарт хөгжмийн зохиолч, Төрийн шагналт Л.Мөрдорж, УГЗ, Төрийн шагналт Г.Цэрэндорж, Ардын жүжигчин П.Хаянхярваа, УГЗ, Төрийн шагналт Д.Бадарч, УГЗ Ш.Гунаажав тэргүүтэй урлагийн бурхдын гараар дамжин миний бие хөгжимчин болсон доо.



Өдгөө гавьяаныхаа амралтад суусан хэдий ч төрөлх чуулгадаа хувь нэмрээ оруулах үүднээс Ахмадын хорооны тэргүүлэгчээр ажиллаж байна. Ингээд хамт ажиллаж байсан мөрдэс нэгт нөхөд, ажилтан, алба хаагчид, үе үеийн удирдлагууддаа түүхт 90 жилийн ойн мэндийг өргөн дэвшүүлж байна.

ДУРСАХ НЭРИЙГ МИНЬ ААВ, ЭЭЖ ДУУРЬСАХ АЛДРЫГ МИНЬ ЭЛ АНСАМБЛЬ МИНЬ НАДАД ХАЯГЛАСАН



Ахмад уран бүтээлч, гоцлол дуучин, МУГЖ Ж.ОДМАА

-1973 онд дунд сургуулиа дүүргээд 1975 онд тухайн үеийнхээр Ардын Армийн Дуу бүжгийн чуулгад дагалдан дуучнаар орж албан тушаалын зэрэглэлийн ахлах байлдагч цол авч байлаа. Миний бие Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгад дуучин хэмээх мэргэжлээр ажиллаж эл ансамблиараа төдийгөөс өдий хүртэл овоглон явж байна. Миний анхны багш

МУГЖ Д.Баянмөнх. Энэ үед Монголын уран бүтээлчдийн нүүр царай, тухайн үеийн урлаг соёлын өнгө төрхийг тодорхойлж байсан хүмүүс бүгд л тус ансамбльд ажиллаж байсан. Тухайлбал МУГЖ Тунгалаг, МУГЖ Отгон, МУГЖ Жанчив, Ардын жүжигчин Баярмагнай зэрэг тооцоод байвал баршгүй. Миний хувьд энэ мундаг хүмүүсийн дунд чадан ядан хөл нийлүүлэн алхаж явснаараа бахархдаг. Мөн н.Лувсанлүндэв, Ардын жүжигчин Д.Мяасүрэн, Монгол Улсын Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн, яруу найрагч П.Бадарч, Урлагийн гавьяат зүтгэлтэн Ш.Гунаажав тэргүүтэй дарга нартай хамтран ажиллаж байсан цаг мөч минь одоо ч тодхон санагддаг. Тэр хүмүүсийн хүчинд л өнөөдрийн намайг бүтээсэн гэж боддог. Тиймдээ ч дурсах нэрийг минь аав, ээж дуурьсах алдрыг минь эл ансамбль минь надад хаяглажээ. Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга бол уран бүтээлчдийг өлгийдөн авч, өсгөн бойжуулаад алдар нэрт хүргэдэг алдрын тайз билээ.

Сая дурдсан бүхэн энэ байгууллагатай өнгөрүүлсэн амьдралын минь 30 жилийн өчүүхэн хэсгийг ч төлөөлж чадахгүй. Хэлж дурсах ёстой нэрс, бахархам түүх өчнөөн байгаа хэдий ч энэ хүрээд өндөрлөж байна. Ингээд дайны цагт ч дуу хуураа таслаагүй Байлдааны гавьяаны улаан тугийн болон Байлдааны гавьяаны одонт цэргийн уран бүтээлчид, ансамблийн бусад хамт олон, ахмадууд, үе үеийн удирдлагууд, энд хуран чуулсан зочид төлөөлөгчид та бүхэнд түүхэн яруу алдарт Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын 90 жилийн ойн мэндийг хүргэе.